



100 жилийн түүхэн эгзэл
1921 оны 05 дугаар сарын 17
№23 /692/

МОНГОЛ
**ТӨРИЙН
МЭДЭЭЛЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1046

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

1048

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1050

**Олон хүүхэд төрүүлж өсгөсөн
эхийг урамшуулах тухай
хуульд нэмэлт оруулах тухай**

**Засгийн газрын үнэт цаас
гаргахыг зөвшөөрөх тухай**

Үндэсний хөтөлбөр батлах тухай





ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|------|
| 246. | Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай | 1046 |
|------|--|------|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 247. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 25 | 1046 |
| 248. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 26 | 1047 |
| 249. | БНМАУ-ын цол, одон, медалийн тухай дүрмийн зарим заалтыг хүчингүй болгох тооцох тухай | Дугаар 27 | 1047 |
| 250. | Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай | Дугаар 28 | 1048 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|--|------------|------|
| 251. | Нийслэлийн шүүхийн танхимын тэргүүнийг томилгох тухай | Дугаар 110 | 1048 |
| 252. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилгох тухай | Дугаар 111 | 1049 |
| 253. | Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай | Дугаар 112 | 1049 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|------|
| 254. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 108 | 1050 |
| 255. | Хоршооллын олон улсын жилийг тэмдэглэх тухай | Дугаар 112 | 1067 |
| 256. | Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 113 | 1073 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.2, 3.3 дахь хэсэг нэмсүгэй:

"3.2. Энэ хуулийн 3.1.1-д заасан "дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн" гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй.

3.3. Энэ хуулийн 4.1.1-д заасан "зургаан хүүхэд төрүүлж өсгөсөн", 4.1.2-т заасан "дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн" гэдгийг энэ хуулийн 3.2-т заасан агуулгаар төсөөтэй хэрэглэж ойлгоно."

2 дугаар зүйл. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын "төрүүлж өсгөсөн," гэсний дараа "бага хүүхэд нь 1 нас хүрсэн," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Ц.Баярсайхан,



Д.Балдан-Очир, С.Бямбацогт, Д.Тэрбишдагва нараас 2010 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Компанийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

**БНМАУ-ын цол, одон, медалийн тухай
дүрмийн зарим заалтыг хүчингүй
болсонд тооцох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 148



дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтаар баталсан "БНМАУ-ын цол, одон, медалийн тухай дүрэм"-ийн ГУРАВ-ын 17, ТАВ-ын 29 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 55.443.4 сая /тавин таван тэрбум дөрвөн зуун дөчин гурван сая дөрвөн зуун мянга/ хүртэлх төгрөгийн, төрийн албан хаагчид болон иргэдэд олгох орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 72 /далан хоёр/ тэрбум хүртэлх төгрөгийн, нийт 127.443.4 сая /нэг зуун хорин долоон тэрбум дөрвөн зуун дөчин гурван сая дөрвөн зуун мянга/ хүртэлх төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг 2011 оны төсвийн жилд тус тус гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар
хот

Нийслэлийн шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасныг баримтлан, Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Батаагийн Батцэрэнг Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээр томилсугай

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар
хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан
тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Жанчиасүрэнгийн Эрдэнэчимэгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, Төмөрбаатарын Ганчимэгийг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн, Үржинбадамдын Одгэрэлийг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Эрдэнэбазарын Дулмаа, Мөнхбаярын Нямбаяр нарыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 112

Улаанбаатар
хот

Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.3 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Пүрэвийн Баттулгыг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашнулуун)-той хамтран баталж, хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөв, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, олон улсын болон хандивлагч байгууллагын төсөл, хөтөлбөрт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2011 оны 108 дугаар
тогтоолын хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Манай улс халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс сэргийлэх ажилд онцгой анхаарч олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд цагаан цэцэг, бөөсний хижиг, халдварт саа өвчнийг устгасан бөгөөд сахуу, татран, хөхүүн ханиад өвчин сүүлийн 4 жил бүртгэгдээгүй, улаанбурхан, В вируст гепатитын өвчлөл тууштай буурч байна.

Засгийн газраас "Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-



ийг 2002-2010 онд хэрэгжүүлснээр халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, санхүүжилт нэмэгдэн оношилгоо, эмчилгээнд орчин үеийн арга, техник технологи нэвтэрч байна.

2005 оноос сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, В хэв шинжийн хемофилюс инфлюэнза нянгийн халдварын эсрэг тавт вакцин, 2009 оноос улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг гуравт вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлсэн.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд нутагшмал халдварт өвчнүүд буурсан боловч халдварт эритем, хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиоз, амьсгалын цочмог халтай хам шинж, гар, хөл, амны өвчин, томуугийн цартахлын А хүрээний (H1N1) шинэ вирусийн халдвар зэрэг шинэ болон дахин сэргэж байгаа халдвар гарснаар 2010 онд халдварт өвчний 41373 тохиолдол бүртгэгдсэнийг өмнөх 10 жилийн өвчлөлтэй харьцуулахад 4457 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Түүнчлэн байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчний голомтыг тогтоох, зрүүлжүүлэх арга хэмжээ авсны үр дүнд тарваган тахлын хүний өвчлөл 2 дахин, нас баралт 24,2 хувиар, галзуугийн хүний өвчлөл 2,2 дахин буурч байгаа хэдий ч боомын хүний өвчлөл нэмэгдэх хандлагатай байна.

Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөрийн хүрээнд "Шууд хяналт дор богино хугацаанд эмчилгээ хийх бодлого"-ыг хэрэгжүүлснээр 2007 оноос сүрьеэгийн тохиолдлын тоо буурч байгаа боловч жил бүр 1000 хүн тутмын 2 нь сүрьеэгээр өвчилж байна. Энэ үзүүлэлтээрээ манай улс ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн өвчлөл өндөртэй 7 орны тоонд орж байна.

Халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх тандалт, хариу арга хэмжээний тогтолцоог 2007 оноос эхлэн үе шаттайгаар бүрдүүлж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын тандалтын нэгжээс халдварт өвчний мэдээг 7 хоног бүр цахим хэлбэрээр авдаг болсноор гар, хөл, амны өвчин, халдварт эритем, амьсгалын замын цочмог халтай хам шинж, улаанууд зэрэг халдварт өвчний дэгдэлтийг богино хугацаанд таслан зогсоосон.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахины уур амьсгалын өөрчлөлт, нянгийн тэсвэржилт, хотжилт, даяаршилтай холбоотойгоор шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнүүд хурдацтай тархаж байгаагийн улмаас халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх тогтолцоо болон салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, халдварт өвчнөөс сэргийлэх



талаар хүн амын мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах нь нэн тулгамдсан асуудал хэвээр байна.

Иймд Олон улсын эрүүл мэндийн дүрэм, "Шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх Ази, номхон далайн бүсийн стратеги", Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Дархлаажуулалтын тухай, Эрүүл мэндийн тухай, Ариун цэврийн тухай хууль зэрэг бодлогын баримт бичгийн хүрээнд "Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр" (цаашид "хөтөлбөр" гэнэ)-ийг шинэчлэн боловсруулав.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ

2.1. Халдварт өвчний эрт сэргэмжлүүлэх тандалт, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах замаар халдварт өвчний тархалтыг хязгаарлахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээг дараахь 9 чиглэлийн дагуу тодорхойлов:

- 2.2.1. Удирдлага, зохион байгуулалт;
- 2.2.2. Салбар хоорондын түншлэл;
- 2.2.3. Тандалт, хариу арга хэмжээ;
- 2.2.4. Мэдээлэл, эрсдэлийн үеийн харилцаа холбоо;
- 2.2.5. Нөөц, бэлэн байдал;
- 2.2.6. Лаборатори;
- 2.2.7. Халдвар хяналт;
- 2.2.8. Хүний нөөцийн хөгжил;
- 2.2.9. Эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл.

2.3. Хөтөлбөрийг 2011-2015 онд хэрэгжүүлнэ.

2.4. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 2.4.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 2.4.2. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;
- 2.4.3. Олон улсын байгууллага, гадаад улс орны төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, тусламж;
- 2.4.4. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус



байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

2.4.5. Бусад эх үүсвэр.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН

3.1. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Зорилт

3.1.1. Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ийг хэрэгжүүлэх чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх;

3.1.2. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Үйл ажиллагааны чиглэл

3.1.3. Аймаг, дүүрэгт халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн алба байгуулан ажиллуулах;

3.1.4. ОУЭМД-ийг хэрэгжүүлэх үндэсний зохицуулах төв болон түүний салбар зөвлөлийг аймаг, нийслэлд байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах;

3.1.5. ОУЭМД-д заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэнийг мэдээлэх, тандах журам боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.6. Халдварт өвчний тандалт, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, зааврыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох.

Хүрэх үр дүн:

Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үндэсний зохицуулах төв болон аймаг, нийслэлд салбар зөвлөл байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжино.

Аймаг, дүүргийн халдварт өвчний тандалт, сэргийлэлтийн албаны үйл ажиллагаа тогтмолжино.

Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх эрх зүйн орчин боловсронгуй болно.



3.2. Салбар хоорондын түншлэлийн талаар

Зорилт

3.2.1. Хүн болон мал эмнэлгийн салбарт "Нэг дэлхий-нэг эрүүл мэнд" зарчмыг хэрэгжүүлж, зоонозын (мал, амьтнаас хүнд дамжих) халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах;

3.2.2. Бүх шатны боловсролын байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах.

Үйл ажиллагааны чиглэл

3.2.3. Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх талаар хүн, мал эмнэлгийн хамтарсан стратеги боловсруулан хэрэгжүүлэх;

3.2.4. Зоонозын халдварын тандалт, хариу арга хэмжээг хүн, мал эмнэлгийн салбар хамтран хэрэгжүүлэх;

3.2.5. Хүн, мал эмнэлгийн лабораторийн хамтын ажиллагаа, ялангуяа хамтарсан судалгааны ажлыг өргөжүүлэх;

3.2.6. Зоонозын халдварт өвчний эрсдэлийн үнэлгээ хийх;

3.2.7. Зэрлэг болон тэжээвэр шувуу, гахай зэрэг амьтдын дунд томуугийн вирусийн эргэлтийг тандан судлах;

3.2.8. ДЭМБ-ын томуугийн мэдээллийн FLUNET сүлжээгээр мэдээлэл тогтмол солилцох;

3.2.9. Бүх шатны боловсролын байгууллагад ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэх;

3.2.10. "Үдийн цай", "Үдийн хоол" хөтөлбөрийн хүрээнд хүнсний хангамжийн нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх замаар хүнсний баталгаат байдлыг хангах.

Хүрэх үр дүн:

Зоонозын халдварт өвчний талаар салбар хоорондын хамтын ажиллагааны стратеги боловсрогдоно.

"Үдийн цай", "Үдийн хоол" хөтөлбөртэй холбоотой хоолны хордлого гарахгүй байх нөхцөл бүрдэнэ.



3.3. Тандалт, хариу арга хэмжээний талаар

Зорилт

3.3.1. Халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний тандалтын тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх;

3.3.2. Халдварт өвчний эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг шуурхай авах чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх;

3.3.3. Дархлаажуултад шинэ вакцин нэвтрүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл

3.3.4. Дүүрэг, аймгийн түвшинд халдварт өвчний дэгдэлтийн үед шуурхай хариу арга хэмжээ авах баг байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

3.3.5. Шуурхай арга хэмжээний багийн гишүүдийг сургалтад тогтмол хамруулах, сургалтын агуулгад халдварт өвчнөөс гадна орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, мал, амьтны эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийн талаар тусгах;

3.3.6. Тандалт, хариу арга хэмжээний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч байх;

3.3.7. Халдварт өвчний эрсдэлийг үнэлэх чадавхийг бүх түвшинд бэхжүүлэх;

3.3.8. Үндэсний хэмжээнд халдварт өвчний эрсдэл, өртөмтгий байдлын тандалт хийж, зураглал гаргах;

3.3.9. Мал, амьтнаас хүнд халдварладаг зарим өвчнийг харуулдан тандаж тархалт, эрсдэлийг тогтоох;

3.3.10. Дархлаажуулалтын хамралтыг сум, дүүрэг, багийн түвшинд нэмэгдүүлэх;

3.3.11. А вируст гепатитын эсрэг вакциныг дархлаажуулалтад үе шаттайгаар нэвтрүүлэх;

3.3.12. Шинэ вакциныг нэвтрүүлэх талаар тандалт, судалгаа хийх;



3.3.13. Хилийн боомтын нэвтрэн орох цэгүүдэд Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;

3.3.14. Хилийн боомтод халдварт өвчний тандалт, хариу арга хэмжээ, гамшгийн бэлэн байдлын арга хэмжээг зохион байгуулж байх.

Хүрэх үр дүн

Дүүрэг, аймгийн түвшинд шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийг халдварт өвчний дэгдэлтийн судалгаа, тархварзүйн үндэс, халдвар хяналт, орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, мал, амьтны эрүүл мэнд, эрсдэлийн харилцаа холбооны чиглэлээр сургалтад хамруулсан байна.

Халдварт өвчний эрсдэл, өртөмтгий байдлын зураглал гарна.

Сум, дүүрэг, багийн түвшинд дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлнэ.

Хилийн томоохон боомтод эрүүл мэндийн болон хил, гааль, онцгой байдлын байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед авах хариу арга хэмжээний чадавхи бүрдэнэ.

3.4. Мэдээлэл, эрсдэлийн үеийн харилцаа холбооны талаар

Зорилт

3.4.1. Халдварт өвчний дэгдэлтийн үед салбар хоорондын хамтын ажиллагаа, мэдээ мэдээлэл солилцох харилцаа холбоо, эргэн мэдээллийг сайжруулах;

3.4.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг соён гэгээрүүлэх, улмаар төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг хүн амд олгох;

3.4.3. Халдварт өвчний дэгдэлтийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүн амыг үнэн зөв мэдээллээр шуурхай хангах;

3.4.4. Халдварт өвчний мэдээ мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх.



Үйл ажиллагааны чиглэл

3.4.5. Халдварт өвчний дэгдэлтийн үеийн харилцаа холбооны салбар хоорондын баг байгуулан ажиллах журам боловсруулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах;

3.4.6. Халдварт өвчнүүдийн талаар холбогдох салбартай хамтран эрсдэлийн үнэлгээ хийж мэдээллийн сан бүрдүүлэх;

3.4.7. Халдварт өвчний дэгдэлтийг сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний дэлхийн сүлжээ (GOARN)-ний үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;

3.4.8. Хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг соён гэгээрүүлэн хэвшүүлэх, халдварт өвчнөөс сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөн хүрээтэй зохион байгуулах;

3.4.9. Халдварт өвчний дэгдэлт, эрсдэлийн үед хүн ам, хэвлэл мэдээллийн ажилтнуудад үнэн зөв мэдээллийг шуурхай хүргэх талаар журам боловсруулан мөрдүүлэх;

3.4.10. Халдварт өвчний бүртгэл, мэдээллийн журам, маягыг боловсронгуй болгож, мэдээллийн цахим тогтолцоо нэвтрүүлэх;

3.4.11. Халдварт өвчний тандалт, хариу арга хэмжээний талаар интернэтэд суурилсан цахим сүлжээг үе шаттай нэвтрүүлж, EWAR 2.0 программ хангамжийг шинэчлэх;

3.4.12. Дархлаажуулалтад хамрагдсан тухай мэдээллийг иргэний цахим бүртгэлд оруулах асуудлыг судлах.

Хүрэх үр дүн

Халдварт өвчний дэгдэлт, эрсдэлийн үеийн харилцаа холбооны асуудлаар салбар хоорондын баг байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжино.

Халдварт өвчний дэгдэлт, эрсдэлийн үед хүн амыг үнэн зөв мэдээллээр шуурхай хангана.

Халдварт өвчний бүртгэл, мэдээллийн цахим тогтолцоо нэвтэрнэ.

3.5. Нөөц, бэлэн байдлын талаар

Зорилт

3.5.1. Халдварт өвчний дэгдэлт, гамшгийн үеийн хариу арга хэмжээнд шаардагдах эм, урвалж бодис, оношлуур, вакцин,



биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, эмнэлгийн багаж, хэрэгсэл, сорьц цуглуулах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн хэрэгцээг тооцох, нөөцлөх, зарцуулалтыг хянах, нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх;

3.5.2. Халдварт өвчний шуурхай хариу арга хэмжээний багийн чадавхийг бэхжүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл

3.5.3. Халдварт өвчний дэгдэлт, цартахлын үед шаардагдах нөөц, бэлэн байдлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;

3.5.4. Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, цартахлын үед шаардагдах эм, урвалж бодис, оношлуур, вакцин, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, эмнэлгийн багаж, хэрэгсэл, сорьц цуглуулах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлэх;

3.5.5. Нөөцийн зарцуулалт, хангамжийг хянах мэдээллийн цахим сан байгуулах;

3.5.6. Халдварт өвчний дэгдэлт, гамшгийн үед хүний нөөц болон олон нийтийг дайчлах, эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх удирдамж боловсруулж, дайчилгаанд шаардлагатай эмнэлгийн орны хүчин чадал, хүний нөөцийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

3.5.7. Халдварт өвчний дэгдэлт, цартахлын үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

3.5.8. Халдварт өвчний шуурхай хариу арга хэмжээний багийг чадавхижуулах, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, бусад хэрэгслээр хангах;

3.5.9. Дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хангалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

3.5.10. Аймгийн түвшинд эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх орны тоог нэмэгдүүлэх, өдрийн эмчилгээний цэгүүд байгуулах;

3.5.11. Вакцины хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн 10-аас доошгүй хувийг жил бүр шинэчлэх.

Хүрэх үр дүн

Халдварт өвчний дэгдэлт, цартахлын үед шаардагдах нөөц, бэлэн байдлын төлөвлөгөө батлагдан, нөөцийн зарцуулалт, хангамжийг хянах мэдээллийн цахим сан бүрдсэн байна.



Халдварт өвчний дэгдэлт, гамшгийн үед нөөц дайчлах эмнэлгийн орны хүчин чадал, хүний нөөцийн талаар мэдээллэлийн сан бүрдсэн байна.

Вакцины хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна.

3.6. Лабораторийн талаар

Зорилт

3.6.1. Лабораторийн чанарт тавих гадаад, дотоод хяналтыг бэхжүүлж, лабораторийн оношилгооны үнэн бодит байдлыг сайжруулах;

3.6.2. Хүн, мал эмнэлгийн оношзүйн лабораторийн сүлжээ байгуулах;

3.6.3. Орон нутгийн түвшинд лабораторийн үйлчилгээг бэхжүүлэх;

3.6.4. Лабораторийн биоаюулгүй ажиллагааг хангах.

Үйл ажиллагааны чиглэл

3.6.5. Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамрагдаж, шинжилгээний чанарт тавих гадаад, дотоод хяналтыг тогтмолжуулан шинжилгээний магадлалыг сайжруулах;

3.6.6. Лабораториудыг үе шаттайгаар магадлан итгэмжлэлд хамруулах;

3.6.7. Халдварт өвчний лабораторийн удирдлага, зохицуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, цахим сүлжээнд хамруулах;

3.6.8. Хүн, мал эмнэлэг болон хүнсний лабораторийн сүлжээ байгуулж, хамтарсан судалгаа, шинжилгээ хийх, мэдээлэл солилцох;

3.6.9. Халдварт өвчний лабораторид оношилгооны шинэ арга нэвтрүүлэх;

3.6.10. Нянгийн антибиотикт тэсвэржилтийн тандалтыг нэвтрүүлэх;

3.6.11. Зарим аймагт вирус судлалын лаборатори байгуулах;

3.6.12. Сорьц цуглуулах, тээвэрлэх зардлыг улсын төсөвт үе шаттай тусгах;

3.6.13. Лабораторийн биоаюулгүйн олон улсын нийгэмлэгт элсэх;

3.6.14. Биоаюулгүй ажиллагааны 3 дугаар зэрэглэлийн лаборатори байгуулах.

Хүрэх үр дүн

Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), томуу, улаанбурхны лабораторийг олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын



сүлжээнд хамруулсан байна.

Лабораторийн нэгдсэн сүлжээ байгуулагдсан байна.

Алс дорнодын хангаар дамжих энцефалит, ханта, япон энцефалит, ернөд нилийн халуурал, өвчний вирусийг өсгөөрлөх шинжилгээ болон бабезиоз, криптоспоридиооз өвчнийг оношлох лабораторийн арга нэвтэрсэн байна.

Ховд, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд вирус судлалын лаборатори байгуулагдсан байна.

Биоажуулгүйн ажиллагааны 3 дугаар зэрэглэлийн лаборатори байгуулагдсан байна.

3.7. Халдвар хяналтын талаар

Зорилт

3.7.1. Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын тогтолцоог үндэсний болон орон нутгийн хэмжээнд бэхжүүлэх;

3.7.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд халдварт өртөх эрсдэлээс хамгаалах.

Үйл ажиллагааны чиглэл

3.7.3. Эрүүл мэндийн бүх шатны байгууллагын халдварын эсрэг хэрэглэх хувийн хамгаалах хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээний стандартыг боловсруулж батлуулах;

3.7.4. Эрүүл мэндийн бүх шатны байгууллага, ялангуяа сумын эмнэлгийн усны хангамж, ариун цэврийн байгууламжийн нөхцөлийг сайжруулах;

3.7.5. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах үйлдвэрийг зарим аймагт байгуулах асуудлыг судлах;

3.7.6. Эмнэлгээс шалтгаалах халдварын тандалтын стандартыг шинэчлэн боловсруулах;

3.7.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэл (шүд, эх барих, эмэгтэйчүүд, мэс засал г.м.)-ээр халдварын эсрэг дэглэмийн заавар, удирдамж, гарын явлага боловсруулах;

3.7.8. Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээнд "эргэх



талон"-ыг нэвтрүүлэх;

3.7.9. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх сургалтад хамруулж, өөрийгөө болон үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангаж, халдвараас сэргийлэх талаар мэдлэг, ур чадварыг нь тогтмол дээшлүүлэх;

3.7.10. Эрүүл мэндийн ажилтнуудын дунд цусаар дамжих болон сүрьеэгийн халдварыг тандан илрүүлж, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.7.11. Эрүүл мэндийн ажилтнууд, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургуульд элсэгчдийг В вируст гепатитын эсрэг дархлаажуулалтад хамруулах;

3.7.12. Эмнэлгийн эмч, ажиллагсдыг улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулж байх.

Хүрэх үр дүн

Эмнэлгээс шалтгаалсан халдварын тандалтын стандарт мөрдөгдөж халдварын илрүүлэлт нэмэгдсэн байна.

Цус, цусан бүтээгдэхүүнээр халдвар дамжихгүй байх нөхцөл бүрдэнэ.

Эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургуульд элсэгчдийг В вируст гепатитын эсрэг дархлаажуулалтад хамруулдаг болно.

3.8. Хүний нөөцийн хөгжлийн талаар

Зорилт

3.8.1. Халдварт өвчний тандалт, эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай тархварзүйн тандалт, судалгааны ур чадвар эзэмшсэн хүний нөөцийг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлэх;

3.8.2. Талбарын тархварзүйн сургалтын тогтолцоо бүрдүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл

3.8.3. Талбарын тархварзүйн сургалтыг эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь албан ёсны мэргэшүүлэх сургалт болгож, сургалтын төрийн сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх;



3.8.4. Талбарын тархварзүйн чиглэлээр багшлах боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх замаар сургалтын чанарыг сайжруулах;

3.8.5. Анагаах ухааны боловсрол олгох сургуулийн төгсөлтийн өмнөх, дараахь сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгож, халдварт өвчний чиглэлээр багшлах боловсон хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;

3.8.6. Халдварт өвчний оношилгоо, тархварзүйн чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг гадаадад сургалтад хамруулах;

3.8.7. Халдварт өвчний тандалт, оношилгоо, эмчилгээ, хариу арга хэмжээний чиглэлээр гарын авлага, сурах бичиг хэвлүүлж, түгээх;

3.8.8. Аймаг, дүүргийн халдварт өвчний хариу арга хэмжээний багт дасгал, үзүүлэх сургалт зохион байгуулах;

3.8.9. Ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйтгэл, шимэгч судлал, биотуршилтын мэргэжилтэн бэлтгэх сургалт зохион байгуулах.

Хүрэх үр дүн

Талбарын тархварзүйн бэлтгэх сургалтыг жил бүр зохион байгуулна.

Халдварт өвчний оношилгоо, тархварзүйн нарийн мэргэжлийн чиглэлээр жил бүр 2-3 эмч, мэргэжилтэнг гадаадад магистр, докторын сургалтад хамруулна.

3.9. Эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл

Зорилт

3.9.1. Эрдэм шинжилгээ, судалгааны санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

3.9.2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр өгөөжийг сайжруулах;

3.9.3. Вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох.

Үйл ажиллагааны чиглэл

3.9.4. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, чадавхижуулах;

3.9.5. Хэчигт энцефалит, бөөм өвчний эмчилгээний иммуноглобулин үйлдвэрлэх стандарт боловсруулж, үйлдвэрлэлийн судалгаа хийх;



3.9.6. Зарим бичил биетний хэв шлөж, антибиотикийн мэдрэг байдлыг тодорхойлох стандарт аргыг нэвтрүүлэх;

3.9.7. Нянгийн өсгөврийг хуурайшуулах аргыг нэвтрүүлэх;

3.9.8. Сүрьеэгийн нянгийн эмэнд дасах механизм болон эрсдэлт бүлгийн хүн амын дундах тархалтыг судлах;

3.9.9. Галзуу, гэдэсний зарим халдварт өвчний вакцин, нян залгиурыг үйлдвэрлэх орчин үеийн технологийг судлан нэвтрүүлэх.

Хүрэх үр дүн

Эрдэм шинжилгээ, судалгааны санхүүжилт нэмэгдэнэ.

Эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээ, судалгаа хийх үр чадвар сайжирч, эрдмийн зэрэг цолтой судлаачдын тоо нэмэгдэнэ.

Хачигт энцефалит, боом өвчний эмчилгээний иммуноглобулин үйлдвэрлэх стандартыг боловсруулж, үйлдвэрлэлийн зэхэц судалгаа хийгдсэн байна.

Галзуу, гэдэсний зарим халдварт өвчний вакцин, нян залгиурыг үйлдвэрлэх орчин үеийн технологийг судлан нэвтрүүлсэн байна.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн яам, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах арга хэмжээг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв зохион байгуулна.

4.2. Орон нутгийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах арга хэмжээг бүх шатны Засаг дарга нар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар бусад мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

| № | Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт 2010 оны байдлаар /хувь, тоо/ | Хүрэх үр дүнгийн үзүүлэлт (оноор) | | | | |
|----|---|---|-----------------------------------|------|------|------|------|
| | | | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
| 1. | Халдварт өвчний дэгдэлтийн үед шуурхай харуу арга хэмжээ авах талаар сургагдсан баг | 15 | 20 | 30 | 40 | 50 | 60 |
| 2. | Халдварт өвчний дэгдэлтийн голомтод 24-48 цагийн дотор харуу арга хэмжээ авсан тохиолдол | 40.0 | 55.0 | 70.0 | 75.0 | 80.0 | 85.0 |
| 3. | Халдварт өвчний хамшинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлын оношлын лабораторийн баталгаажилт | 40.0 | 45.0 | 50.0 | 60.0 | 70.0 | 80.0 |
| 4. | Эрсдэлийн үеийн харилцаа хэлбэрийн чиглэлээр сургагдсан мэргэжилтэн | 50 | 100 | 150 | 200 | 250 | 300 |
| 5. | Шинэ болон сэргэж байгаа халдварт өвчний дэгдэлт, томиугийн цартахлын үед харуу арга хэмжээ авах талаар хамтран хийсэн үзүүлэх сургууль | 3 | 5 | 5 | 10 | 10 | 15 |
| 6. | Халдварт өвчний дэгдэлтийн үеийн харилцаа холбооны чиглэлээр сургагдсан баг | 0 | 5 | 10 | 15 | 20 | 20 |
| 7. | Халдварт өвчний үед хэрэглэх хувийн хамгаалах хэрэгсэлээр хангагдсан эрүүл мэндийн байгууллага | 10.0 | 20.0 | 30.0 | 40.0 | 60.0 | 80.0 |

| | | | | | | | |
|-----|---|------|------|------|------|------|-------|
| 8. | Лабораторийн сорьц цуглуулах багцар хангагдсан эрүүл мэндийн байгууллага | 10,0 | 20,0 | 30,0 | 40,0 | 60,0 | 80,0 |
| 9. | Халдварт өвчний оношилгооны чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн лаборатори | 2 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 10. | Халдварт өвчний оношилгоонд нэвтэрсэн молекул-биологийн шинжилгээний арга | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 11. | Олон улсын лавлагаа лабораторийн чанарын хяналтын сүлжээнд хамрагдсан лаборатори | 2 | 3 | 4 | 6 | 6 | 6 |
| 12. | В энуст гелатинаас сэргийлэх вакцинд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн | 5,0 | 20,0 | 30,0 | 40,0 | 50,0 | 60,0 |
| 13. | Томуугийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн | 10,0 | 20,0 | 30,0 | 40,0 | 50,0 | 60,0 |
| 14. | Эмнэлгийн ажиллагсдын халдварт өртсөн байдлыг тогтмол мэдээлдэг эрүүл мэндийн байгууллага | 6,0 | 15,0 | 25,0 | 40,0 | 50,0 | 60,0 |
| 15. | Цус, цусан бүтээгдэхүүний эргэх таланыг хэрэглэж хэвшсэн эрүүл мэндийн байгууллага | 0 | 20,0 | 40,0 | 60,0 | 80,0 | 100,0 |
| 16. | Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээний талаар хийсэн судалгаа | 9 | 12 | 15 | 17 | 20 | 22 |



| 17. | Халдварт өвчний тандагт, хариу арга хэмжээний талаар хийсэн дэмжлэгт хяналт | 10 | 20 | 30 | 40 | 50 | 60 |
|-----|---|------|------|------|------|------|------|
| 18. | Шинээр нэвтрүүлсэн вакцин | 0 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| | Биобэлдмэл | 0 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| | Биобэлдмэл, оношлуур | 0 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 19. | Цусан суулга | 11.2 | 11.0 | 10.0 | 9.0 | 9.0 | 9.0 |
| 20. | Сальмонеллэ | 0.8 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.6 | 0.5 |
| 21. | A вирус гепатит | 33.8 | 21.0 | 21.0 | 15.8 | 13.0 | 10.0 |
| 22. | Улаан-бурхан | 0.06 | 0.01 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 23. | Улаанууд | 5.9 | 5.0 | 4.5 | 4.0 | 3.5 | 3.0 |
| 24. | Гахай хаадаар | 7.9 | 7.5 | 7.0 | 7.0 | 6.5 | 6.0 |
| 25. | Сурьээгийн нас баралт (100,000 хүн амд) | 2.5 | 2.3 | 2.1 | 1.9 | 1.7 | 1.5 |
| 26. | Түрхэц эерэг сурьээгийн тохиолдлын илрүүлэлт | 83.7 | 84.0 | 84.3 | 84.5 | 84.7 | 85.0 |
| 27. | Түрхэц эерэг сурьээгийн шинэ тохиолдлын эдгэрэлт | 83.4 | 83.8 | 84.0 | 84.4 | 84.7 | 85.0 |
| 28. | ХДХВ-ийн халдварыг шинжилгээ хийлгэсэн сурьээтэй авчгын | 35.0 | 43.0 | 51.0 | 59.0 | 67.0 | 75.0 |
| 29. | Жирэмсэн эмэгтэйнүүдийн дундахь тэмбүүгийн тархалт (судалгаагаар) | 1.7 | 1.3 | | | | 1.0 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 112

Улаанбаатар
хот

Хоршооллын олон улсын жилийг тэмдэглэх тухай

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 64 дүгээр чуулганаас 2012 оныг "Хоршооллын олон улсын жил" болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хоршооллын олон улсын жилийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний хороог 1 дүгээр хавсралт, Хоршооллын олон улсын жилийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. "Хоршоолсон үйлдвэрлэлээр төгөлдөр дэлхийг бүтээхүй" сэдэвт олон улсын бага хурлын бэлтгэл ажлыг хангаж, 2011 оны 5 дугаар сарын 3-наас 6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

3. Хоршооллын олон улсын жилийг угтаж хоршоодын үйл ажиллагааг дэмжсэн бодитой, бүтээлч арга хэмжээ авч хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусган ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

Г.ЗАНДАНШАТАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2011 оны 112 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ХОРШООЛЛЫН ОЛОН УЛСЫН ЖИЛИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Хорооны дарга -Монгол Улсын Шадар сайд М.Энхболд

Гишүүд: -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
Т.Бадамжунай;

-Гадаад харилцааны сайд Г.Занданшатар;

-Улсын Их Хурлын дэд дарга, Монголын хоршооллын үндэсний
нэгдсэн холбооны тэргүүн Н.Энхболд (зөвшилцсөнөөр);

-Говь-Алтай аймгийн Засаг дарга Ш.Амгаланбаяр;

-Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан
(тохиролцсоноор);

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Баттөр;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн
үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Д.Бадарч;

-Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын
захирал С.Онон;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн
төлөвлөлтийн газрын дарга Н.Агзуш;

-Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн
хамтын ажиллагааны газрын орлогч захирал С.Жавхланбаатар;

-Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны
ерөнхийлөгч Н.Баяртсайхан (тохиролцсоноор);

-Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбооны
ерөнхийлөгч Ч.Алтангаяа (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга

-Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Ц.Ням-Осор

**ХОРШООЛЛЫН ОЛОН УЛСЫН ЖИЛИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|-----------|---|
| 1 | Хөрөнгө, хөдөлмөрөөр хоршын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, ажлын байр шинээр бий болгож байгаа аж ахуй эрхлэх хэлбэрийг олон нийтэд сурталчилж, хоршооллын хөдөлгөөнийг идэвхжүүлэх | 2011-2012 | ХХААХҮЯ, ГХЯ, Жижиг, дунд үйлдвэрийн газар /ЖДУГ/ |
| 2 | НҮБ-аас 2012 оныг хоршооллын олон улсын жил болгон зарласантай холбогдуулан олон улсын бага хурал зохион байгуулах | 2011 | ГХЯ, ХХААХҮЯ, ЖДУГ |
| 3 | 2011 оны сүүлчээр болох Ерөнхий Ассамблейн бүгд хуралдаан Хоршооллын олон улсын жилийг албан ёсоор эхлүүлэн нээх тул өндөр түвшинд оролцох | 2011-2012 | ГХЯ, ХХААХҮЯ, ЖДУГ |
| 4 | НҮБ-ын гишүүн улс, НҮБ-ын системийн байгууллага, хоршоолол, төрийн байгууллагуудын оролцоог хангасан дугуй ширээний албан бус хэлэлцүүлэгт хоршооллын төлөөллийг оруулах | 2011-2012 | ГХЯ, ХХААХҮЯ, ЖДУГ, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо /МХҮНХ/ |
| 5 | Монгол Улсаас гадаад оронд суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан хоршоодын үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг гадаад оронд сурталчлан таниулах үзэсгэлэн, худалдааг зохион байгуулах, түүнд хоршоодыг өргөнөөр оролцуулах | 2011-2012 | ГХЯ, ХХААХҮЯ, ЖДУГ, МХҮНХ, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар /АНЗДТГ/ |



| | | | |
|----|---|-----------|---|
| 6 | Ази, Номхон далайн хоршооллын холбооноос техникийн туслалцааг авах чиглэлээр ажиллах, хоршоолол өндөр хөгжсөн гадаад орны туршлагыг нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | 2011-2012 | ГЯА, ХААХУЯ, ЖДУГ, МОНХ, АНДДТГ |
| 7 | Хоршоологчдод дэмжлэг үзүүлэх, харилцан туршлага солилцох, сурталчлах зорилгоор хоршооны бие даасан үзэсгэлэн, худалдааг зохион байгуулах, бусад үзэсгэлэн, худалдаанд хоршоологчдыг өргөнөөр оролцуулах | 2011-2012 | ХААХУЯ, ЖДУГ, МОНХ, АНДДТГ |
| 8 | Хоршооллын аяныг аймаг бүрт өрнүүлж, "Нэг аймаг- хоёр Брэнд" аянг зохион байгуулах | 2011-2012 | ХААХУЯ, ЖДУГ, МОНХ, АНДДТГ |
| 9 | Монгол Улсад хоршооллын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг утсан жилийн ажлын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг төвлөвөн зохион байгуулах | 2011 | ХААХУЯ, ЖДУГ, МОНХ, АНДДТГ |
| 10 | Хоршооллын түүхэн хөгжлийн асуудлаар онол практик, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах | 2011 | ХААХУЯ, ЖДУГ, МОНХ |
| 11 | Нийслэлийн төв гудамж дагуу байрлах сурталчилгааны самбаруудад ойн анонс, хэвлэмэл хуудас байршуулах | 2011-2012 | ХААХУЯ, ЖДУГ, АНДДТГ |
| 12 | Монгол Улсад хоршооллын салбар үүсч хөгжсөний 90 жилийн түүх, ололт амжилт, үнэт зүйлсийг тайлбарласан нийтлэлийг өдөр тутмын сонин хэвлэлд гаргах, вэб сайтad байршуулах, нэвтрүүлэг, уулзалт ярицлагыг радио, телевизээр бэлтгэж нэвтрүүлэх | 2011 | ХААХУЯ, ЖДУГ, МОНХ, АНДДТГ |
| 13 | Хоршооллын түүхийн баримтат кино хийх | 2011-2012 | ХААХУЯ, ЖДУГ, МОНХ |
| 14 | Хоршооллын салбарыг сурталчилсан телевизийн танин мэдэхүйн болон цэнгээнт нэвтрүүлэг хийх | 2012 | ХААХУЯ, ЖДУГ, МОНХ |



| | | | |
|----|---|-----------|---|
| 15 | Хоршооллын салбарыг хөгжүүлэх талаар их, дээд сургуулийн оюутан, залуучуудын дунд уралдаан зарлах | 2012 | ХХААХҮЯ, БСШЯ, ЖДҮГ, МАҮНХ, АНЗДТ |
| 16 | Хоршооллын чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2011-2012 | ХХААХҮЯ, ГХЯ, ЖДҮГ, МАҮНХ, АНЗДТ |
| 17 | Албан бус хөдөлмөр эрхлэлтийг хоршооны хэлбэрт шилжүүлэх, тухайн бус нутагтаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа хоршоодыг дэмжих | 2011-2012 | ХХААХҮЯ, НОХР, ЖДҮГ, МАҮНХ, АНЗДТ |
| 18 | Хөдөө аж ахуйн чиглэлээр загвар хоршоодыг бий болгож чадавхижуулах | 2011 | ХХААХҮЯ, ЖДҮГ, МАҮНХ, АНЗДТ |
| 19 | Хоршоодын төрөлжсөн инкубатор төв байгуулах асуудлыг шийдвэрлэх | 2012 | СБ, ХХААХҮЯ, НОХР, ЖДҮГ |
| 20 | Хоршооны хууль эрх зүйн орчинд мэргэжлийн байгууллагын шинжилгээ хийлгэх, боловсронгуй болгох санал боловсруулах | 2011-2012 | ХХААХҮЯ, ЖДҮГ, МАҮНХ, АНЗДТ |
| 21 | Хөрөнгө, хөдөлмөрөөрөө хоршин үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, ажлын байр шинээр бий болгож байгаа хоршоодод хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалт болон шаардлагатай тоног төхөөрөмжийг лизингээр олгоход дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн урамшууллын системийг нэвтрүүлэх | 2011-2012 | ХХААХҮЯ, НОХР, ЖДҮГ, АНЗДТ |

| | | | |
|----|--|-----------|-----------------------------------|
| 22 | Зайны сургалтуудыг бүх аймгийг хамруулан зохион байгуулах, сургалтын гарын авлагыг CD хэлбэрээр гаргаж, орон нутагт хүргүүлж сургалтууд зохион байгуулах | 2011-2012 | ХЯААХҮЯ, НООЯ, ЖДҮТ, АНДДТГ |
| 23 | Хоршооллын олон улсын жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг аймаг, нийслэл бур гаргаж ажиллах | 2011-2012 | АНДДТГ |
| 24 | Олон улсын хоршооны жилийн арга хэмжээний хүрээнд хоршоодын холбоодорос зохион байгуулж байгаа ажлыг дэмжин үр дүнг дээшлүүлэх | 2011-2012 | МОНХ, ХЯААХҮЯ |
| 25 | Төрийн зарим чиг үүргийг хоршоодын холбоогоор гүйцэтгүүлэх замаар төр, хоршооллын хамтын ажиллагааг хөгжүүлэх | 2011-2012 | ХЯААХҮЯ, МОНХ |
| 26 | Хоршооны сургалт, мэдээллийн төвийг түшиглэн хоршооны төрөлжсөн сургалт зохион байгуулах | 2011-2012 | МОНХ, ХЯААХҮЯ |
| 27 | Хоршооны банк байгуулах болон, арга замын талаар сургалт зохион байгуулах | 2012 | МОНХ, ХЯААХҮЯ |
| 28 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр болон аймаг, нийслэлийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах | 2011-2012 | ХЯААХҮЯ, ЖДҮТ, АНДДТГ |
| 29 | Хоршооллын олон улсын жилийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон энэ чиглэлээр аймаг, нийслэл, хоршоодын холбоодорос зохион байгуулж байгаа ажлын явцыг Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэж, эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах | 2011-2012 | Үндэсний хороо |
| 30 | Хоршооллын олон улсын жилийн арга хэмжээний зардлыг 2012 оны улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх | 2011-2012 | ХЯААХҮЯ, АНДДТГ |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 113

Улаанбаатар
хот

Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Ойн тухай хуулийн 11.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 248 дугаар тогтоолоор баталсан "Ойн тухай үндэсний хөтөлбөр"-т дараахь нэмэлт оруулсугай:

"Найм, Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

1. Ойн тухай хууль тогтоомж, стандарт, ойн менежментийн төлөвлөгөө болон энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох байгууллага, иргэний нийгэм, эрдэмтэд, шинжээчийн хөндлөнгийн үнэлгээ;

2. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, мод, түүний дагалт баялгийг ашиглах чиглэлээр шинэ техник технологи нутагшуулан нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, нөхөрлөлийн тоо, тэдгээрийн эдийн засгийн үр дүн;

3. Ойжуулах ажил, ойн зам байгуулах арга хэмжээ болон техник технологийн шинэчлэлтэд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт;

4. Мод, сөөгний үрийн улсын нөөц болон иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн бэлтгэсэн мод, сөөгний үрийн нөөцийн хэмжээ, түүний өсөлт;

5. Шинээр байгуулсан мод үржүүлгийн газрын тоо, нэмэгдсэн ажлын байр, жил бүрийн ойжуулсан талбайн хэмжээ, түүний дотор хөнөөлт шавьж, өвчинд өртсөн болон түймэрт нэрвэгдсэн талбайн ойжуулалтын хэмжээ, нийт тарьсан мод, түүний ургалтын хувь, улсын ойн санд хүлээлгэн өгсөн таримал ойн хэмжээ (га);

6. Мод бэлтгэлийн аж ахуйн нэгж, иргэний өөрийн хөрөнгөөр хийсэн ойжуулсан талбай, тавьсан ойн замын тухай үзүүлэлтүүд;

7. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах болон мод тарих ажилд орон нутгийн иргэдийн оролцооны хувь, иргэдийн орлогын өсөлт;

8. Мод бэлтгэлийн аж ахуйн нэгж, мод боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, чанарын үзүүлэлтүүд, модны ашиглалтын түвшний хувь;

9. Олзворлож боловсруулсан ойн дагалт баялгийн нэр төрөл, тоо хэмжээ;



10. Модон бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээний хангалтын хувь."

2. "Ойн тухай үндэсний хөтөлбөр"-ийн "Хөтөлбөрийн зорилго, зорилт" гэсэн Хоёрдугаар зүйлийн "Хоёр"-ыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"Хоёр. 1. Ойн аж ахуйн арга хэмжээг менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, ойн, ойн дагалт баялгийг зохистой ашиглах, ойн нөөц бүхий зарим бүс нутагт ойн төв зам байгуулах;

Хоёр. 2. Мод боловсруулах үйлдвэрүүдэд орчин үеийн техник технологийг нэвтрүүлэн нутагшуулж, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэн уламжлалт болон шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх."

3. "Ойн тухай үндэсний хөтөлбөр"-ийн "Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл" гэсэн Дөрөвдүгээр зүйлийн "Хоёрдугаар зорилтын хүрээнд" гэснийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"Хоёрдугаар зорилтын 1-ийн хүрээнд:

1. Ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, нөхөрлөл бүр ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллаж хэвших;

2. Мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж байгаа жижиг аж ахуйн нэгжүүдийг техник технологио бие дааж шинэчлэх чадвар бүхий төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж болгон бүсчлэн байгуулж ажиллуулах;

3. Мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагад ойн санг гэрээгээр эзэмшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулах;

4. Мод, модон материалын бирчийг нийслэл хот болон ойн нөөц бүхий зарим бүс нутагт зохион байгуулж ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулах;

5. Модон зүсмэл материал бэлтгэхэд зөврийн болон суурин ажиллагаатай зүсвэрийн туузан хөрөөг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

6. Ашиглах боломжтой ойн дагалт баялгийн нэр төрөл, нөөцийг тогтоож, тэдгээрийн байршил, түүж ашиглах хугацааг бүс нутгаар гаргаж мөрдүүлэх;

7. Самар, жимс, мөөг, эмийн ургамал зэрэг ойн дагалт баялгийг бэлтгэж ашиглах заавар, зөвлөмж, гарын залага боловсруулж мөрдүүлэх;

8. Ойн хортон шавьжинд нэрээгдсэн, түймэрт өртсөн, өтлөн хуурайшиж хатсан мод, унагни болон бэлтгэсэн модны үзүүр, ёзоор, тэйрдэс, хэлтдэг, дахин боловсруулж, цэвэр модон материал оргох төрөл бүрийн хавтан, наамал дүнд, дүнзэнцэр үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэх аж ахуйн нэгжийг хөнгөлөлтэй зээлийн бодлогоор дэмжих;



9. Төмөр замын дэрийг модноос өөр материалаар орлуулах арга хэмжээг зохион байгуулах;

10. Модны шилмүүснээс эфирийн тос, витаминг нунтаг, эмчилгээний ханд болон шинэс, нарс модноос давирхай олборлон канифол, скипидар, хус модноос нүүрс гарган авах үйлдвэрлэлийг ой модны үйлдвэрүүдийг түшиглэн байгуулах, бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх арга хэмжээг дэс дараалалтай авч хэрэгжүүлэх;

11. Ойн дагалт баялгийг бэлтгэж, боловсруулах ажлыг өргөжүүлэх, нэр төрлийг олшруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12. Ойн дагалт баялаг болох зэрлэг жимс, самар, мөөг, хүнсний болон эмийн ургамлыг бэлтгэн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

13. Ойн төв зам байгуулах бүс, нутаг дэвсгэрийг тогтоох судалгаа хийж, төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох;

14. Ойн нөөц бүхий зарим аймагт улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн хөрөнгөөр ойн төв зам шинээр байгуулж эхлэх.

Хоёрдугаар зорилтын 2-ын хүрээнд:

1. Импортын мод, модон материалыг нэмүү өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж хуулийн төсөл боловсруулах;

2. Төрөл бүрийн модлог хавтан, фанер, барилгын хаалга, цонх, паркетан шал зэрэг зарим нэрийн бүтээгдэхүүний дотоод зах зээлийг хамгаалах асуудлыг судалж санал боловсруулах;

3. Төсвийн байгууллагын захиалгат мебель болон модон тавилгыг үндэсний үйлдвэрүүдийг сонгон шалгаруулж үйлдвэрлүүлэх чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

4. ОХУ-аас бөөрөнхий мод, зүсмэл материал хөнгөлөлттэй нөхцөлөөр импортлох, тус улсад ойн сан гэрээгээр эзэмших чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх санал тавих, хамтран ажиллах;

5. Ахуйн хэрэглээний болон барилгын зориулалттай модон бүтээгдэхүүний стандартыг шинэчлэх, шинээр боловсруулж батлуулах замаар бүтээгдэхүүний чанарыг олон улсын жишигт хүргэх ажлыг зохион байгуулах;

6. Модон материалыг хаягдалгүй иж бүрэн ашиглах техник технологийг нутагшуулах үйлдвэрүүдийг хөрөнгө оруулалтын болон санхүүгийн түрээсийн зээлд хамруулах ажлыг зохион байгуулах;

7. Малчид, хөдөөгийн иргэдийн өргөн хэрэгцээний модон эдлэл, гэрийн мод үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүдийг Архангай, Булган, Дорнод, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг, төв суурин газруудад байгуулах төслийг хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжиж хэрэгжүүлж эхлэх;

8. Үйлдвэр технологийн паркийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинэ дэвшилтэт техник технологи бүхий "Барилгын модон хийцийн



цогцолбор үйлдвэр²-ийг байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

9. Олон улсын стандарт, чанарын шаардлага хангасан модон материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, модон бүтээгдэхүүний импортын хэмжээг 50 хүртэл хувиар бууруулах арга хэмжээ авах;

10. Ойн нөөцгүй бүс нутгийн мод боловсруулах жижиг үйлдвэрүүдийг модон материал, бэлдэцээр хангах арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах;

11. Наамал, матмал модон эдлэл, фанер, мебелийн хуулга үйлдвэрлэх дэвшилтэт технологи бүхий жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулахад дэмжлэг үзүүлэх;

12. Дотоодын үйлдвэрүүдийн модон бүтээгдэхүүний үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийн олон улсын үзэсгэлэн, худалдаанд салбарын аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг зохион байгуулалттай оролцуулах;

13. Ойгоос бэлтгэн ашиглаж байгаа нэг шоометр модны ашиглалтыг 60-аас доошгүй хувьд хүргэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх.”

4. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2011 оны II улиралд багтаан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ,
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turijn_medeelal@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

Индex: 14003

